

БУРХАН БИДЭНД БИБЛИЙГ ӨГСӨН ЗОРИЛГЫГ

МЭДЭХ НЬ



БИБЛИЙГ ДАРААХ ЗОРИЛГООР БИДЭНД ӨГСӨН

-Хоньдыг минь хариулаарай Хичээл:

Сүнстэй хамт алхах-

Чиглэл (Хаашаа явах)

Зааварчилгаа (Хэрхэн амьдрах)

Даруу байдал (Амьдралаас хэрхэн таашаал авах)

Байлдан дагуулах (Миний амьдрал дахь оногдсон зүйл)

Залруулга (Хэрхэн төлөвших)

Сургаал (Хэрхэн үйлдэх)

3. БИБЛИЙГ ДАРААХ ЗОРИЛГООР БИДЭНД ӨГСӨН

Чиглэл (Хаашаа явах)

Зааварчилгаа (Хэрхэн амьдрах)

Даруу байдал (Амьдралаас хэрхэн таашаал авах)

Байлдан дагуулах (Миний амьдрал дахь оногдсон зүйл)

Залруулга (Хэрхэн төлөвших)

Сургаал (Хэрхэн үйлдэх)

3.1 ТАХИЛЧ НАР 1000 ЖИЛИЙН ТУРШ ХРИСТТЭЙ ХАМТ ХААНЧЛАХ БОЛНО.

Би сэнтийнүүдийг харав. Тэд дээр нь заларчээ. Тэдэнд шүүх эрх өгөгдсөн байлаа. Мөн Есүсийн гэрчлэл болон Бурханы үгээс болж цаазлуулсан хүмүүсийн сүнснүүдийг, араатанд ба түүний хөрөгт мөргөөгүй, дух хийгээд гар дээрээ араатны тэмдгийг хүлээн аваагүй хүмүүсийг би харав. Тэд амилаад Христтэй хамт мянган жилийн турш хаанчилжээ. 5 Үхэгсдээс үлдсэн нь мянган жилийг дуустал амилсангүй. Энэ бол анхны амилалт юм. 6 Анхны амилалтад багтсан хүн ерөөлтэй агаад ариун юм. Хоёр дахь үхэл тэднийг захирах ямар ч хүчгүй ажээ. Харин тэд Бурханы ба Христийн тахилч нар болцгоож, Түүнтэй хамт мянган жилийн турш хаанчлах болно. (Илч 20:4 - 6)

Хэрэв Үгийн дэмжлэггүй эсвэл Үгийн нотолгоо байхгүй болохыг баталсан бол энэ нь хууран мэхлэлт төдийгүй мөнхийн аврал үгүй бөгөөд итгэмжит биш юм. Та Эзэнтэй хамт анхны дахин амилалтанд орж 1000 жил хаанчилж, шинэ тэнгэр, шинэ газарт ороход бэлэн байна уу?

Бид илүү баттай болгогдсон эш үзүүлэгийн үгтэй. Үүр цайж, үүрийн цолмон зүрхэнд тань гийх хүртэл, харанхуй газарт гэрэлтэж буй дэнлүүг анхаарах мэт та нар түүнд анхаарал тавихдаа сайн байдаг. 20 Судрын нэг ч эш үзүүлэг эш үзүүлэгчийн өөрийнх нь тайлбараар ирээгүйг юуны түрүүнд мэдэгтүн. 21 Учир нь нэг ч эш үзүүлэг хэзээ ч хүний хүслээр гарсангүй, харин Ариун Сүнсээр хөдөлгөгдсөн хүмүүс Бурханаас айлджээ. (2 Петр1:19 - 21)

3.2 УТГЫГ НЬ МЭДЭХ: СҮНСИЙГ СОНСОХ

[] Энэ харанхуй ертөнцөд үүр цайх хүртэл та гэрэл гэгээгээ асаах тэвчээртэй байна уу?


[] Эш үзүүллэгийг Ариун Сүнсээр хөдөлгөгдсөн хүн л зөв тайлбарлах боломжтой гэдгийг та мэдэх үү?

Маргалдаан нь хариулт шийдлийг бус улам олон маргалдаанд хүргэдэг. Хэрэв та дуулгавартай бөгөөд мөн итгэж байвал Түүний үгэнд заасан зүйлийг хийгээсэй гэж л Бурхан хүсдэг. Бидний тарьж, хураадаг зүйл бол бидний амьдрал, дэлхийн түүхийн гэрчлэл юм. Бурхан надаас миний бодлыг эсвэл чадах бүхнээ хийж байгаа эсэхийг асуудаггүй. Харин Түүний замаар явж байгаа эсэхийг асуудаг. Яагаад? Учир нь үл үзэгдэгч, үхэшгүй мөн бүх зүйлийг бүтээсэн Мөнхийн Бурхан, бүх зүйлийг эзэмшигч Тэр бол ганцаараа л үнэхээр юу нь зөв, сайн зүйл болохыг мэддэг юм. Саул, Ананиа, Сафира нарын адилаар дэлхийн голдрилыг бүү дага. Давид, Уззиа нар шиг зүүн эсвэл баруун тийш бүү хазай. Өөрийн бодлоор бус, харин Их Эзэний Сүнсээр удирдуул.

3.3 ДЭЛХИЙН ГОЛ ДОЛООН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ


<http://www.gotquestions.org>

<http://www.livereal.com>



3.4 СҮМИЙН ТҮҮХ УРСГАЛУУД

Урсгал: Библийг заахдаа сүмийн тэргүүн болох Христийн төлөө гэхээсээ илүү тухайн нийгмийн таалалд нийцүүлсэн хувцаслалт, төлөв гэх мэтэд ач холбогдол түлхүү өгсөн өөр сонголт, тайлбар үүсгэсэн протестантизм нь 15-р зууны орчимд эхэлсэн. **Сайн**-гаж урсгал, хуурамч сургаалаас хамгаалдаг. **Муу**- хайж эрэлхийлэгч нэгнүүдэд эргэлзээ, төөрөгдөл үүсгэн Ариун Сүнс-Бурханыг хүний санаагаар хязгаарладаг. **Анхаараарай** - "Миний шүтлэгийн урсгал" Теологи бол Библийг хүний аргаар тайлбарлаж буй юм. (Иохан 14-ийг бясалга)



3.5 БИЧИГДСЭН ЗҮЙЛЭЭС БҮҮ ХЭТЭР

6 Ах дүү нар аа, би эдгээрийг та нарын төлөө өөртөө болон Аполд хэрэгжүүлсэн нь та нар бичигдсэнээс хэтрэхгүй байхыг биднээс суралцаасай гэсэндээ юм. Тэгвэл та нар нэгийнхээ төлөө нөгөөгийнхөө эсрэг их зантай болохгүй. (1 Коринт 4:6)

18 Хуурамч даруу байдалд таашаал аван, тэнгэр элч нарт мөргөдөг, үзсэн үзэгдлээ баримтлан, махан биеийн ухаанаар өөрийгөө дэмий хоосон дөвийлгөдөг ямар ч хүн та нарын шагналыг бүү булааг. (Колоссай 2:18)

[] Бурханы Үгнээс гадна ажиллах нь таны өөрийн эсвэл бузар муу нэгэний нөлөөнд автсан ажил эсвэл Бурханы хүслийн эсрэг гэдгийг та мэдэх үү?

Болгоомжтой бай:

- Хүн бүр өвчнөөсөө эдгэрэхийг Бурхан хүсдэг гэж хэлээгүй.
- Есүс бүх хүнийг эдгээгээгүй.
- Бурхан хүн бүрийг баян эсвэл ядуу байхыг хүсдэг гэж хэлээгүй.
- Бурхан биднийг сахиусан тэнгэрүүдэд тушааж чадна гэж хэлээгүй.
- Бурхан бүгд харь хэлээр ярих ёстой гэж хэлээгүй.

Бүхий л үйл дээрээ Библийг дагаж мөрдөөрэй. Бурханы үгнээс гадна талд баригдсан бүх зүйл нь Түүний хангамж, хамгаалалтаас гадуур бөгөөд дайсны нутаг дэвсгэр дээр бүтээгдсэн юм.

3.6 ДЭЛХИЙН ҮЗЭЛ

<u>Дэлхийн үзэл</u>	<u>Юу бодит вэ?</u>
Итгэл үнэмшил	Юу үнэн бэ?
Үнэ цэнэ	Юу чухал вэ?
Зан төлөв	Юу хийдэг вэ?

Алсын харааны мэдэгдэл:
Та юу хийхийг хүсч байна вэ?
Эрхэм зорилго:
Чи юу харж байна?
Үнэ цэнийн мэдэгдэл:
Юу чухал вэ?


Бидний таамаглал нь бидний хэтийн төлөв, хэтийн төлөв нь бидний тэргүүлэх чиглэлийг тодорхойлдог. Бидний тэргүүлэх чиглэл нь бидний практикийг тодорхойлдог. " - Кеннет Боа -

Дэлхийн үзлийн ойлголт



Христитгэл дэлхийн үзэл

Сөнөх гэж буй нь үхэл,
алдагдах гэж буй нь алдагдсан
гэдгийг бодож үзэх



3.7 ҮГ ҮГҮЙ БОЛ ИТГЭЛ ҮГҮЙ

Библийг унших болон түгээх явцын улмаас дэлхийн эрх баригчидын хавчлагад хамгийн их өртсөн сөргөлдөөнтэй тулгарсаар ирснээс гадна үгийг нь ихэвчлэн буруу ойлгож, буруу тайлбарлаж, зохисгүй харьцаж, зүй бус хэрэглэж ирсэн байна.

Библийн түүхэн замнал яагаад цус, зоволгоор дүүрсэн байдаг вэ? Бурхан яагаад Төгс хүчит Өөрийн хүч чадал, мэргэн ухаанаар үүнийг зөвшөөрсөн бэ? Өнөөдөр Бурханы үгс зөвхөн сонсох чихтэй хүмүүст л хүрдэг. Яагаад? Бурхан бүх зүйлийг бүтээсэн; Түүний хэлсэн үгсийг сайн дураараа хүлээн авах нь итгэл юм.

4 Итгэлээр Абел Каиныхаас үлэмж дээр тахилыг Бурханд өргөв. Үүгээрээ тэр зөвт байсан гэсэн гэрчлэлийг хүлээн авав. Бурхан түүний бэлгүүдийн тухай гэрчилсэн юм. Хэдийгээр тэр үхсэн боловч итгэлээр ярьсаар байна. 5 Итгэлээр Енох үхлийг үзэлгүй дээш аваачигдсан. Бурхан түүнийг дээш аваачсан учраас тэр олдсонгүй. Тэр аваачигдахынхаа өмнө Бурханд таалагдсан тул гэрчлэл хүлээн авчээ. 6 Итгэлгүйгээр таалагдана гэдэг боломжгүй юм. Учир нь Бурхан уруу ирж буй хүн Тэр байдаг гэдэгт болон Өөрийг нь хайгч хүмүүст Тэр Шагнагч нь болдог гэдэгт итгэх ёстой. 7 Итгэлээр Ноа хараахан харагдаагүй байсан зүйлсийн талаар сэрэмжлүүлэл аваад гэр бүлийнхээ авралын төлөө хөвөгч авдрыг сүсэглэн бэлдсэн бөгөөд тэр түүгээр дэлхийг яллаж, итгэлийн дагуу зөвт байдлыг өвлөгч болжээ. (Еврей 11:4 – 7)

[] Та Библийн зорилгыг мэдэх үү?

[] Библи бол Бурханы ҮГ гэдэгт та итгэдэг үү?

[] Итгэл нь зөвхөн Бурханы Үгнээс гаралтай гэдгийг та мэдэх үү?

3.8 БУРХАНЫ ҮГИЙГ СОНССОНООР ИТГЭЛ НЬ ИРДЭГ.

16 Харин тэд сайн мэдээнд итгэсэнгүй. Учир нь Исаиа «Эзэн, бидний мэдээнд хэн итгэсэн бэ?» гэж хэлсэн. 17 Тиймээс итгэл нь сонсохоос, сонсох нь Христийн үгээр ирдэг. 18 Гэвч би хэлье. Тэд хэзээ ч сонсоогүй гэж үү? Үнэндээ тэд сонссон. «Тэдний дуу хоолой бүх газарт, Тэдний үгс дэлхийн зах хязгаарт ч хүрсэн» гэсэн байдаг. 19 Гэвч би хэлье. Израиль

үнэндээ мэдээгүй юу? Эхлээд Мосе «Би үндэстэн биш хүмүүсээр та нарыг атаархуулж, ухаангүй үндэстнээр уурлуулна» гэсэн. 20 Исаиа зоригтойгоор «Намайг хайгаагүй хүмүүс Намайг олсон. Намайг сураглаагүй хүмүүст Би илэрхий болсон» хэмээн хэлсэн юм. 21 Харин Израилийн талаар Тэр «Бүхэл өдөржин Би дуулгаваргүй, зөрүүд ард түмэнд гараа сунгасан» гэжээ. (Ром 10:16 - 21)

[] Таньд итгэл байна уу? Үүнийгээ Бурханы өмнө өөрийнхөө хувьд л байлга.

Зөвшөөрдөг зүйлдээ өөрийгөө ялладаггүй хүн нь ерөөлтэй еэ! Харин эргэлзэгч нэгэн нь хэрэв идэх аваас ялагдана. Яагаад гэвэл итгэлээр биш юм. Итгэлээр биш алив бүхэн нь нүгэл юм. (Ром 14:22 – 23)

[] Та Христ дотор эрх чөлөөг мэдэрдэг үү?

[] Итгэлээр хийгээгүй бүхэн нь яагаад нүгэл болохыг та мэдэх үү?

[] Танд итгэл байна уу? Бурханы өмнө үүнийг өөртөө зориул

Үг үгүй = Итгэл байхгүй

Итгэл үгүй = Ариун Сүнсний ажил үгүй

Ариун Сүнсний ажил үгүй = Зөвт байдал үгүй

АНХААР:


Таны үйлдлийг хүмүүс болон Бурхан хардаг гэдгийг мэдэж аваарай.

Ухамсрын амар амгалан бол таны хаана байгааг илтгэх үзүүлэлт гэдгийг мэдэх нь зүйтэй.

Дэлхийтэй эвлэрэх нь зөвхөн ухралт ба урхинд хүргэдэг гэдгийг мэдээрэй.

Нүгэлд бүү авт, дайснуудад ч бүү зай гарга.

3.9 ТАРИАЛАХ БА ХУРААХ



Махан биеийн үхлийн дараа - шүүлт эсвэл шагнал

Тиймд бид хэрэгцээтэй цагт туслах нигүүлслийг олон, өршөөлийг хүлээн авахын тулд нигүүлслийн хаан ширээнд итгэлтэйгээр ойртон очигцооё. Евр 4:16

